



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 35 болон 36 дэх долоо хоног


ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 8-р сарын 20-ноос 9-р сарын 03-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 22 дахь дугаарыг хүргэж байна.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- Дэлхийн улс орнуудын эдийн засгийн гүйцэтгэлд үндэслэн ОУВС-ийн нэгтгэсэн тооцооллоор **2020 оны 2-р улиралд дэлхийн эдийн засаг 5.4 хувиар агшжээ**. Хөгжингүй орнуудын эдийн засаг 11.9 хувиар агшсан бол эрчимтэй хөгжиж буй орнуудын эдийн засаг 0.5 хувиар агшсан байна (Зураг 1.).



NOTE: The advanced economies (excl. U.S.) aggregate includes the Euro Area, Japan, the U.K., Canada, Australia, South Korea, Switzerland and Sweden. The emerging economies aggregate includes China, Brazil, Russia, India, Mexico, Indonesia, Turkey, Argentina, South Africa and Colombia. The world aggregate includes these countries, which make up approximately 80 percent of world GDP computed using purchasing power parity (PPP)-adjusted GDP weights.

SOURCES: National Statistical Offices, International Monetary Fund; Haver Analytics Globalization Institute Federal Reserve Bank of Dallas

Зураг 1. Дэлхийн эдийн засгийн өсөлт

- 2020 оны 2-р улирлын эцэст “CNBC”-ээс Дэлхийн тэргүүлэх байгууллагуудын санхүү хариуцсан захирлуудын дунд явуулсан судалгаагаар **2020 онд БНХАУ-ын эдийн засаг АНУ-ын эдийн засгаас илүү эрчимжих хандлагатай** гэж дүгнэсэн байна. Уг судалгааны үр дүнд

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт "тогтвортой" байгаа бол АНУ-ынх 2 дахь улиралдаа дараалан "аажуу буурах" хандлагатай гэсэн таамагтай байна. Харин бусад Азийн орнууд болон Евро бүсийн эдийн засгийн таамаг өмнөхөөсөө сайжирч “аажмаар буурах” хандлагаас “тогтвортой” төлөвт шилжсэн байна.

- Энэ оны 8-р сарын 31-нд Ройтерс агентлагаас 21 эдийн засагч, шинжээчдийн дунд явуулсан санал асуулгад **ОХУ-ын Төв банк 2020 онд бодлогын хүүгээ дахин бууруулж, 4 хувьд хүргэнэ** гэсэн таамаглал давамгайлж байна. Беларусийн Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн, Кремлийн шүүмжлэгч Алексей Навальнийг хордуулсан гэх сэжиглэл зэрэг геополитикийн асуудлууд шийдэгдвэл Оросын Төв банк 9-р сардаа багтан бодлогын хүүгээ 0.25 нэгж хувиар бууруулж 4 хувьд хүргэх бөгөөд 2021 оны туршид энэ түвшинд нь хадгалах хүлээлттэй байна. Мөн тус улсын эдийн засаг 2020 онд 4.7 хувиар агшиж, 2021 оны 2-р улирлаас эхлэн сэргэж, 2021 онд 3.2 хувийн өсөлттэй



байх төлөвтэй гэж үзжээ¹. Инфляц энэ оны төгсгөл гэхэд 3.7 хувьд хүрэх буюу өмнөх санал асуулгын үр дүнтэй ижилхэн байна.

- **АНУ-ын Холбооны нөөцийн банкнаас 2020 оны 8-р сарын 27-ны өдөр мөнгөний бодлогын стратегидаа оруулсан өөрчлөлтийг олон нийтэд зарлав.** АНУ-ын ХНБ-ны урт хугацааны зорилт болох бүрэн ажил эрхлэлт, 2 хувийн Инфляцын түвшинд өөрчлөлт ороогүй ч эдгээр зорилтдоо хэрхэн хүрэх стратегид өөрчлөлт оруулав. Нээлттэй зах зээлийн хороо (FOMC) мөнгөний бодлого хэрэгжүүлэхдээ Инфляцыг **дунджаар 2 хувьд** хадгалах стратегийг баримтлах юм. Ингэснээр Инфляцын зорилт илүү уян хатан болж, ХНБ бодит эдийн засаг, ажил эрхлэлт рүү чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх орон зай нэмэгдлээ гэж шинжээчид дүгнэж байна. Түүнчлэн сүүлийн жилүүдэд Инфляц тогтмол зорилтот 2% түвшнээс доогуур хадгалагдсанаар Инфляцын хүлээлт бага түвшинд тогтох эрсдэлээс сэргийлэхэд Инфляцын зорилтыг дунджаар хангах энэхүү шинэ стратеги тус болно гэж үзэж байна. Цаашид жил бүрийн эхэнд зарчмуудаа эргэн харж, шаардлагатай өөрчлөлтийг оруулах бөгөөд мөнгөний бодлогын стратеги, арга хэрэгслүүд, олон нийттэй харилцах туршлагыг 5 жил тутамд олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэх ажлыг хийхээ мэдэгдлээ.
- **Евро бүсийн үйлчилгээний салбарын PMI индекс 7-р сард 54.7 байсан бол 8-р сард 50.1 болж буурсан байна.** Тус индекс нь 50-аас дөнгөж дээгүүр байгаа нь эдийн засгийн идэвхжиж байгаа хэдий ч тэлэлтийн хурд маш бага байгааг харуулж байна.
- **Евро бүсийн орнуудад хэрэгжүүлсэн төсвийн багц хөтөлбөрүүд өрхийн**

хэрэглээг дэмжиж байгаа ч **хөдөлмөрийн захын нөхцөл байдал сул хэвээр байгаа нь хэрэглэгчдийн итгэлийг бууруулж** байгаа аж. Евро бүсэд хамгийн сайн үзүүлэлттэй байгаа Германы хөдөлмөрийн зах дээрх нээлттэй ажлын байрны зар 8-р сарын эхэн үеийн байдлаар цар тахлын өмнөх 2-р сартай харьцуулахад 15 хувиар буурсан байна. Уг үзүүлэлт Франц улсад мөн хугацаанд 25 хувиар, Их Британид 50 хувиар тус тус буурчээ. Түүнчлэн, өнгөрсөн саруудад Евро бүсэд ажилгүйдлийн түвшин АНУ-тай харьцуулахад харьцангуй бага байсан нь Евро бүсийн улсуудын ЗГ-аас компаниудад ажилчдаа цалинжуулахад зориулж тэтгэмж өгч байсантай холбоотой. Харин энэхүү тэтгэмжийн хөтөлбөр нь энэ намар дуусах бөгөөд ажилгүйдлийн түвшин өсч, өрхийн орлого огцом буурах эрсдэл тулгараад байна. Түүнчлэн компаниуд ажилчдаа цомхотгох хүлээлт өндөр байна. Мөн ажилгүйдлийн түвшин огцом өсөх нь эдийн засгийн сэргэлтэд сөргөөр нөлөөлж, гүн хямралд хүргэх магадлалтай гэж зарим шинжээчид үзэж байна. Зарим улс өрийн дарамтад орохоос сэргийлж эдийн засгаа сэргээхэд нэмэлт санхүүжилт гаргах боломжгүй байгаа тул Европын Холбооноос дахин нэмж санхүүжилт гаргах магадлалтай байна. Мөн Европын Төв банк болон Английн Төв банк цаашид ч мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлж, хөрвөх чадвартай хөрөнгийг санхүүгийн зах зээлд нийлүүлэх шаардлага үүсч магадгүй байна.

- Atradius байгууллагын тооцооллоор 2020 онд **дэлхий дахинд корпорацуудын дампуурал 26 хувиар нэмэгдэхээр** байна. Оны эхний хагаст улс орнуудын хэрэгжүүлсэн төсвийн дэмжлэгүүдийн зэрэгцээ дампуурлын нөхцөлүүдийг зөөлрүүлсэн нөлөөгөөр корпорацуудын дампуурал буурсан

¹ Харин үүний өмнөх санал асуулгад Оросын эдийн засаг 2020 онд 4.3 хувиар агшиж, 2021 онд 2.7 хувиар өснө гэсэн таамаглалтай байсан юм.



дүр зурагтай байна. Харин оны сүүлийн хагаст төсвийн бодлогын үр нөлөө алгуур арилах, ихэнх орнуудад түр зуурын дампуурлын тухай хуулиуд 3-р улирлаас хүчинтэй хугацаа дуусч байгаа тул дампуурлууд огцом нэмэгдэж болзошгүй байна.

- **Азийн нэгдсэн аж үйлдвэрийн PMI индекс 8-р сард өмнөх сараас нэмэгдэв.** Үүнд БНХАУ, Австрали, Өмнөд Солонгос, Тайландын аж үйлдвэрийн PMI индекс 50-аас дээгүүр түвшинд хадгалагдсан бол Индонезийн PMI индекс хүлээлтээс ихээр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. Харин Малайз, Филиппин, Вьетнам зэрэг орнуудын PMI индексүүд өмнөх сараас буурч 50-аас доогуур түвшинд хүрэв. Азийн улс орнуудад оны эхний хагаст эрчимтэй мөнгөний сул бодлого хэрэгжүүлж байсан бол 7-р сард дийлэнх Төв банкууд хүүгээ бууруулалгүй “түр зогсов”. Харин Шинэ Зеландын Төв банк актив хөрөнгө худалдан авах хөтөлбөрийн хэмжээг ойролцоогоор 65 тэрбум

ам.долларт хүргэж, хугацааг 2022 оны 6-р сар хүртэл сунгалаа.

Эх сурвалж:

1. Poytrec, [Russia to cut rates in 2020, helping economy to grow in 2021: Reuters Poll](#)
2. Deliotte, [Weekly global economic update August 2020](#)
3. The New York Times, [Europe Tried to Limit Mass Layoffs, but the Cuts Are Coming Anyway](#)
4. Haver Analysis, [Database Profiles](#)
5. CGTN, [Global CFOs more positive about China's economic outlook than the U.S.: Survey](#)
6. Atradius, [2020 insolvencies forecast to jump due to Covid-19](#)
7. Dallas Fed, [Global Economic Conditions \(August, 2020\)](#)
8. Federal Reserve System, [Review of Monetary Policy Strategy, Tools, and Communications](#)

2 БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **БНХАУ-ын аж үйлдвэрийн Caixin PMI индекс 7-р сард 52.8 хүрсэн бол 8-р сард 53.1 хүрч нэмэгдэв.** Үүнд гадаад эрэлт нэмэгдэн, шинэ захиалгын тоо өсөлттэй байсан нь нөлөөлөв. **БНХАУ-ын аж үйлдвэрийн албан ёсны PMI индекс 7-р сард 51.1, 8-р сард 51.0 хүрч тэлэлт үргэлжиллээ.** Үүнд эрэлт хадгалагдсан, шинэ экспортын захиалгын тоо нэмэгдсэн нь голлон нөлөөллөө. Дэд индексүүдээс ажил эрхлэлтийн бүрэлдэхүүн индекс бага зэрэг өссөн ч 50-аас доогуур түвшинд хадгалагдсан нь компаниуд ажилчдынхаа төвлөрлийг бууруулсан хэвээр байгааг харуулж байна. **БНХАУ-ын аж үйлдвэрийн бус албан ёсны PMI индекс 7-р сард 54.2 хүрсэн бол 8-р сард 55.2 хүрч хүлээлтээс ихээр нэмэгдэв.** Үүнд үйлчилгээний салбарын сэргэлт нэмэгдэн, Засгийн газрын барилгын салбарыг дэмжих бодлогын нөлөөгөөр барилгын салбарын PMI индекс 60-аас дээгүүр хадгалагдсан нь нөлөөлөв.
- **БНХАУ-ын Шанси, Шаанси, Хэбэй, Шандонг, ӨМӨЗО-ны коксжих нүүрс нийт үйлдвэрлэл оны эхний 7 сард 269.0 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 2 хувиар буурав.** Шанси муж, Өвөр Монголын үйлдвэрлэл оны эхний 7 сард 60.3 сая тонн, 23.3 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 3.7 хувь, 6.1 хувиар тус тус нэмэгджээ. Харин Хэбэй, Шандонг мужийн үйлдвэрлэл харгалзан 28.2 сая тонн, 20.0 сая тоннд хүрч 5.6 хувь, 26.3 хувиар тус тус буурав. Зөвхөн 7-р сарыг авч үзвэл Өвөр Монгол, Шанси мужийн үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 11.4 хувь, 12.3 хувиар тус тус нэмэгдсэн бол Хэбэй, Шандонг мужуудын үйлдвэрлэл 6.4 хувь, 40.1 хувиар тус тус буурлаа.
- **БНХАУ-ын Шанси, Шандонг, Гуазоу (Guizhou), Хэнань мужуудын дотоодын угаасан коксжих нүүрсний нийт үйлдвэрлэл оны эхний 7 сард 270.6 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар буурав.** Түүнчлэн, Шанси мужийн үйлдвэрлэл оны эхний 7 сард өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар нэмэгдсэн бол Шандонг, Гуазоу, Хэнань мужийн угаасан нүүрсний үйлдвэрлэл 6.0 хувь, 25.2 хувь, 7.6 хувиар тус тус буурав. Зөвхөн 7-р сарыг авч үзвэл Шанси, Шандонг, Гуазоу, Хэнань мужуудын үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 3.2 хувь, 4.7 хувь, 19.5 хувь, 14.7 хувиар тус тус буурчээ.
- Нүүрсний импортын хориг тавигдаагүй тул **7-р сард БНХАУ-ын нүүрсний нийт импорт 7.4 сая тонн болж жилийн 4.9 хувиар буурлаа.** Харин оны эхний 7 сард нийт импорт 45.5 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 3.2 нэмэгдэв. БНХАУ-ын Австралиас импортолсон коксжих нүүрсний хэмжээ 7-р сард 4.5 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 13.1 хувиар нэмэгдсэн бол Канад, Монгол, ОХУ-аас импортолсон коксжих нүүрсний хэмжээ 0.04 сая тонн, 2.2 сая тоннд, 0.5 сая тоннд тус тус хүрч өмнөх оны мөн үеэс 79.9 хувь, 14.5 хувь, 30.1 хувиар тус тус буурав. Харин оны эхний 7 сард Австрали, Канад Улсуудаас импортолсон коксжих нүүрсний хэмжээ 28.6 сая тонн, 2.7 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 53.8 хувь, 45.3 хувиар тус тус нэмэгдсэн бол Монгол, ОХУ-аас импортолсон коксжих нүүрсний хэмжээ 9.5 сая тонн, 3.4 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 50.7 хувь, 4.0 хувиар тус тус буураад байна. **БНХАУ-ын эрчим хүчний нүүрсний**



импорт 7-р сард 18.7 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 25.5 хувиар буурав. БНХАУ-ын Индонезоос импортолсон эрчим хүчний нүүрсний хэмжээ өмнөх оны мөн үеэс 25.0 хувиар буурч 7-р сард 10.6 сая тоннд хүрсэн, Австрали, ОХУ-аас импортолсон эрчим хүчний нүүрсний хэмжээ 4.1 сая тонн, 2.8 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 34.0 хувь, 17.6 хувь тус тус буурсан бол Монгол Улсаас импортолсон нүүрсний хэмжээ 0.34 сая тоннд хүрч 74.4 хувиар нэмэгдлээ.

- **БНХАУ-ын автомашины үйлдвэрлэл 7-р сард 2.3 саяд хүрч өмнөх оны мөн үеэс 26.8 хувиар нэмэгдэв.** Үүний зэрэгцээ автомашины борлуулалт 7-р сард 2.1 саяд хүрч

өмнөх оны мөн үеэс 16.4 хувиар нэмэгдлээ. БНХАУ-ын автомашины үйлдвэрлэлийн сэргэлт зэсийн эрэлт, үнэд эерэгээр нөлөөлж байгаа юм. Харин оны эхний 7 сараар авч үзвэл автомашины үйлдвэрлэл 12.6 саяд хүрч жилийн 9.7 хувиар, автомашины борлуулалт 12.4 саяд хүрч жилийн 12.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эх сурвалж:

1. China React: PMIs show recovery on track, demand kicking in, Bloomberg
2. Asia React: Manufacturing sees more progress, a few setbacks too, Bloomberg
3. China React: Caixin PMI shows exports helping sustain recovery, Bloomberg
4. China Commodities Today, Bloomberg
5. China Coking coal market monthly: August, Sxcoal.com
6. China Thermal coal monthly: August, Sxcoal

3 МОНГОЛБАНК, ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

Төрийн үйлчилгээ, тэр дундаа төрийн үйлчилгээний төлбөр тооцоог цахимжуулах ажил сүүлийн жилүүдэд эрчимтэй хэрэгжиж байна. Саяхныг хүртэл иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээ, тэр дундаа лавлагаа, тодорхойлолт, хүсэлт, өргөдөл зэрэг бүхий л бичиг баримтын бүрдүүлэлтийн явц олон дамжлага дамжиж, тэдгээр үйлчилгээний төлбөр тооцоог хийхэд банканд давхар дугаарлах, мөн өндөр шимтгэл төлөх дарамт байсаар ирсэн. Энэ нь цаг хугацаа алдах, үргүй зардал үүсгэх замаар иргэдийн дунд ихээхэн бухимдал үүсгэж байсан юм. Хэдийгээр төрийн зарим үйлчилгээ цахим хэлбэрт шилжсэн хэдий ч төлбөр төлөх үйлчилгээ нь цахимжиж чадахгүй байсан нь төрийн үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжих боломжийг хязгаарлаж байв.

Тус нөхцөл байдлыг өөрчилж, төрийн үйлчилгээний төлбөр тооцоог түргэн шуурхай хүргэх, зардал чирэгдлийг арилгах үүднээс Монголбанк нь Төрийн үйлчилгээний төлбөр тооцоог цахимжуулах ажлыг 2016 оноос эхлүүлж, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх үүднээс тодорхой зохицуулалтыг бий болгон, өөрийн системд програм хангамжийн хөгжүүлэлтийг хийж, төрийн үйлчилгээний төлбөр тооцоог гүйцэтгэх дэд бүтцийг бий болгосон. Ингэснээр Сангийн Яамны Төрийн сангийн газрын өмнөөс иргэдийн төрийн үйлчилгээний төлбөрийг Монголбанк картын системээр дамжуулан хүлээн авч, төрийн байгууллагын дансанд гүйлгээг нэгбүрчлэн, бодит цагийн горимоор тусгах ажлыг гүйцэтгэж байна.

Өнгөрсөн оны мөн үеэс өнөөдрийг хүртэлх хугацаанд нийт 75 мянган ширхэг төрийн үйлчилгээний гүйлгээ дамжсан байна.

Одоогийн байдлаар Монголбанк нь Нийслэлийн засаг даргын тамгын газар, Татварын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар зэрэг байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан, эдгээр байгууллагын зарим үйлчилгээний төлбөр тооцоог цахимжуулах ажлыг гүйцэтгэж байна.

Монголбанк, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар хооронд хамтран ажиллах гэрээг өнөөдөр байгууллаа. Гэрээг байгуулан ажилласнаар тус газраас нэвтрүүлж буй E-Mongolia цахим порталаар дамжих бүхий л төрийн үйлчилгээний гүйлгээ Монголбанкаар дамжин төлөгдөх боломж бүрдэх ба энэхүү томоохон төсөл амжилттай хэрэгжих үндэс суурь болох юм. Өөрөөр хэлбэл 180 орчим төрлийн төрийн үйлчилгээний төлбөр Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийн системд боловсруулагдаж, тухайн агшин бүрд харилцагчийн гүйлгээ баталгаажиж, гүйлгээ нь бодит цагийн горимоор Төрийн сангийн газрын дансанд тусна.

Цаашилбал, Монголбанк нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Төлбөрийн картын системийг энэ ондоо багтаан бүрэн нэвтрүүлэх, мөн үндэсний төлбөрийн EMV chip стандарт бүхий Т картыг ойрын хугацаанд нийлүүлэх зорилт тавин ажиллаж байна.



4

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ӨӨРЧЛӨЛТҮҮД

(2020.08.13-09.03)

- Төгрөгийн ам.доллартай харьцах ханш оны эхнээс **3.7%**, өмнөх оны мөн үеэс **6.8%**-иар сулраад байна /2020.09.03-ны байдлаар/.
- ТОП-20 индексийн үзүүлэлт **17,069** болж өмнөх оны мөн үеэс 13.6%-иар буураад байгаа боловч сүүлийн 14 хоногийн хугацаанд харьцангуй тогтвортой байна /2020.08.13-ны байдлаар/.

14 ХОНОГИЙН МЭДЭЭ						
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Нэгж	Тайлант үе	Өмнөх үе	Өмнөх оны	Өөрчлөлт	Өсөлт
		/2020.09.03/	/2020.08.13/	мөн үе /2019.09.03/	/2020.08.13- 2020.09.03/	/өмнөх оны мөн үе/
Валютын урсгал болон хани						
Ам.долларын ханш	₮	2,853.4	2,848.5	2,671.8	5.0	6.8%
Хөрөнгийн зах						
ТОП-20 индекс		17,068.9	16,540.3	19,760.1	528.6	-13.6%
МУ-ын бондуудын өгөөж						
Монгол 2021 - МАЗААЛАЙ	%	3.8	4.2	4.8	-0.4	-19.4%
Монгол 2022 - ЧИНГИС	%	3.8	4.3	4.7	-0.5	-19.0%
ХХБ САМУРАЙ	%	1.3	1.3	0.5	0.0	144.2%
Монгол 2024 - Хуралдай	%	4.7	5.1	5.4	-0.4	-13.6%
Монгол 2023 - Гэрэгэ	%	4.1	4.5	4.9	-0.4	-17.0%
МУХБ	%	5.4	6.0	6.6	-0.6	-17.7%
МИК	%	13.1	13.0	10.2	0.1	27.9%

Тайлбар: Хүснэгтэд 2020 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн байдлаарх хамгийн сүүлийн үеийн тоон мэдээг тусгасан бөгөөд зарим тоон мэдээ нь яг тус өдрийнх биш байна.


Хөрөнгийн зах /2020.09.03/:

Зураг 1. Хөрөнгийн биржийн Тор-20 индекс



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Зураг 2. МУ-ын бондуудын өгөөж (%)



Эх сурвалж: Монголбанк

ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ СУУРЬ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө 2020 оны 7 дугаар сарын байдлаар **78.6%**-тай, нийт зарлага ба цэвэр зээлийн төлөвлөгөө **83.9%**-тай биелсэн буюу төсвийн орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 21.4%-иар, төсвийн зарлага төлөвлөснөөс 16.1%-иар буурсан байна.
- 2020 оны 8 дугаар сарын байдлаар гадаад худалдааны эргэлт **7,244.3 сая ам.доллар** гарч, тэнцэл **866.0 сая ам.долларын ашигтай** гарлаа.
- Зөвхөн 8 дугаар сарын эхний 15 хоногт 266.5 сая ам.долларын экспорт, 247.1 сая ам.долларын импорт хийсэн байна.
- 2020 оны 7 дугаар сарын инфляц улсын хэмжээнд **3.4%**, Улаанбаатар хотын хэмжээнд **3.2%** гарлаа.
- Зээл олголтын хэмжээ 6 дугаар сард 1.96 их наяд төгрөг байсан нь 7 дугаар сард 1.88 их наяд төгрөг болж 3.9%-иар буурсан байна. Харин зээл төлөлт 1.71 их наяд төгрөгөөс 1.81 их наяд төгрөг болж 5.8%-иар өслөө.


САРЫН МЭДЭЭ						
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Нэгж	Тайлант үе	Өмнөх үе	Өмнөх оны мөн үе	Өөрчлөлт	Өсөлт
		/2020.07/	/2020.06/	/2019.07/	/2020.06-2020.07/	/өмнөх оны мөн үе/
Монгол Улсын нэгдсэн төсөв						
Орлого						
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж	тэрбум ₮	4,900.3	4,100.3	6,035.0	19.5%	-18.8%
Татварын орлого	тэрбум ₮	4,495.6	3,742.9	5,485.2	20.1%	-18.0%
Татварын бус орлого	тэрбум ₮	404.7	357.4	549.8	13.2%	-26.4%
Зарлага						
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	тэрбум ₮	7,365.9	6,298.3	5,499.8	17.0%	33.9%
Урсгал зардал	тэрбум ₮	5,852.8	5,050.8	4,518.2	15.9%	29.5%
Хөрөнгийн зардал	тэрбум ₮	1,481.7	1,228.9	867.9	20.6%	70.7%
Цэвэр зээл	тэрбум ₮	31.3	18.7	113.7	67.8%	-72.4%
Гадаад худалдаа*						
Худалдааны эргэлт	сая \$	7,244.3	6,730.7	8,650.4	7.6%	-16.3%
Экспорт	сая \$	4,055.2	3,788.7	4,860.7	7.0%	-16.6%
Импорт	сая \$	3,189.1	2,942.0	3,789.7	8.4%	-15.8%
Худалдааны тэнцэл	сая \$	866.0	846.6	1,070.9	2.3%	-19.1%
Инфляц						
Жилийн инфляц /Улс/	%	3.4	2.8	8.1	21.4%	-58.0%
Жилийн инфляц /УБ хот/	%	3.2	2.4	9.6	33.3%	-66.7%
Банкны зээлийн тайлан						
Зээлийн хэмжээ						
Олгосон зээл /тухайн сард/	тэрбум ₮	1,884.3	1,960.0	1,718.6	-3.9%	9.6%
Төлөгдсөн зээл /тухайн сард/	тэрбум ₮	1,808.5	1,710.0	1,584.4	5.8%	14.1%
Зээлийн үлдэгдэл	тэрбум ₮	17,022.9	17,042.0	17,309.8	-0.1%	-1.7%

* Гадаад худалдааны мэдээ нь 15 хоногийн давтамжтай байна.



Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл /2020.07/:

Зураг 3. Татварын орлогын задаргаа, сараар



Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

Хүснэгт 1. Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж, 1 дүгээр улирал

	Төсөв	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Татварын орлого	5,578,121	4,495,609	80.6%	(1,082,511.8)
Татварын бус орлого	659,683.5	404,666	61.3%	(255,016.7)
Нийт орлого ба тусламжийн дүн	6,237,804	4,900,276	78.6%	(1,337,528.5)

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк


Хүснэгт 2. Нийт зарлага ба цэвэр зээл

	Төсөв	Гүйцэтгэл	Хувь-1	Зөрүү
Урсгал зардал	6,614,030.2	5,852,813.0	88.5%	(761,217.3)
Хөрөнгийн зардал	2,058,641.9	1,481,723.0	72.0%	(576,918.9)
Цэвэр зээл	109,467.0	31,348.8	28.6%	(78,118.2)
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	8,782,139.1	7,365,884.8	83.9%	(1,416,254.4)

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк


Гадаад худалдаа /2020.08.15/:

Зураг 4. Гадаад худалдааны эргэлтийн өсөлт, сараар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Зураг 5. Экспорт, импорт, тухайн сараар




Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар



Инфляц:


Зураг 6. Инфляц, сараар



Эх сурвалж: Монголбанк

Банкуудын зээлийн тайлан:

Зураг 7. Зээлийн эргэн төлөлт, тэтгэврийн зээлийг хассан, 2020.07 /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк



5 МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

	Бодит гүйцэтгэл						Товч тайлбар
	Үнэ (-1 day) 2020/09/01	Өөрчлөлт				YoY	
		daily	weekly	monthly	year to date		
Зэс	6709.7	0.0%	1.4%	3.3%	8.9%	20.0%	БНХАУ-ын үйлдвэрлэлийн салбарын идэвхжил хадгалагдаж, улс орнуудын хөл хорио суларч эхэлсэн, эрэлт нэмэгдсэн, нөөц буурсан нөлөөгөөр үнэ өмнөх долоо хоногийн түвшнээс нэмэгдэхэд нөлөөлөв.
Коксжих нүүрс	113.2	-	-	-	-	-38.5%	Худалдааны маргаан, КОВИД-19-ийн нөлөөгөөр эрэлт нэмж буурах төлөв болон БНХАУ-ын дотоодын үйлдвэрлэл нэмэгдэх нөлөөгөөр үнэ бага түвшинд хадгалагдаж байна.
Төмрийн хүдэр	126.2	0.0%	2.3%	13.5%	36.4%	36.5%	БНХАУ-ын гангийн үйлдвэрлэлийн сэргэлт үргэлжилсэн, боомтууд дээрх нөөц нэмэгдэж буй, хөл хорионы улмаас Бразил Улсын нийлүүлэлт буурахаар байгаа хэдий ч энэ нь богино хугацаанд шийдвэрлэгдэх хүлээлтийн нөлөөгөөр үнэ өмнөх долоо хоногоос нэмэгдэв.
Алт	1970.2	-1.4%	-0.6%	1.7%	27.1%	25.1%	Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал өндөр байгаа тул аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны эрэлт өндөр байна.
Газрын тос (Брент)	45.6	-2.5%	-2.7%	0.6%	-32.9%	-24.3%	АНУ дахь нөөц хадгалагдсан, олон улсын эрчим хүчний агентлаг газрын тосны эрэлтийг 5-р сарын төсөөллөөс нэмэгдүүлсэн ч КОВИД-19-ийн тархалт нэмэгдсэн хэвээр, ОПЕК-ийн нэгдэл+ нийлүүлэлтээ танасан ч 8-р сараас эхлэн тус хэмжээг өдрийн 9.6 сая баррелиас 7.7 сая баррель болгосон нөлөөгөөр сулруулж эхлэх нөлөөгөөр үнийн өсөлт хадгалагдаж байна.